



МОНГОЛЫН АРХИТЕКТУРУУДЫН ЭВЛЭЛИЙН

ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монголын Архитекторуудын Эвлэлийн шагналаар Архитектурын салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа, архитектурын шилдэг бүтээл туурвисан архитектор, инженерүүд. Удирдах ажилтан, бодлого боловсруулагч, багш сурган хүмүүжүүлэгч, зураач, барималч, дизайнер, археологич, архитектурын хөгжилд хувь нэмэр оруулсан монголын болон гадаадын иргэдийн уран бүтээлийг үнэлж шагнал олгоно.
- 1.2 Архитектурын урлагийг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг бодитой үнэлэх, тэдгээрийг дэмжиж хөгжүүлэх, сурталчлах, ажлын идэвх санаачлага, үйл ажиллагааг өрнүүлэхэд энэхүү шагналын зорилго оршино.
- 1.3 МАЭ-ийн шагнал нь МАЭ-ийн шагнал, Урамшуулал гэсэн 2 төрөл байна.
- 1.4 МАЭ-ийн шагналыг МАЭ-ийн Их хурал, түүхэн ой, зураг төслийн байгууллагын ой нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баяр ёслол, тэмдэглэлт өдрийг тохиолдуулан олгоно.
- 1.5 Мэргэжлийн ур өндөр ур чадвар, архитектор мэргэжлийн зөвлөх үйлчилгээний олон улсын дүрмийг биелүүлж, архитекторуудын нэр хүндийг өргөсөн гишүүд, гишүүн байгууллагыг шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. МОНГОЛЫН АРХИТЕКТУРУУДЫН ЭВЛЭЛИЙН ШАГНАЛ

2.1 Монголын Архитекторуудын Эвлэлийн шагнал нь дараах төрөлтэй байна

- “ШИЛДЭГ БҮТЭЭЛ”
- “ШИЛДЭГ АРХИТЕКТОР
- “ШИЛДЭГ ЗАЛУУ АРХИТЕКТОР
- “ШИЛДЭГ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА”

2.2 МАЭ-ийн Урамшуулал дараах төрөлтэй байна.

- МАЭ-ийн Хүндэт гишүүн
- МАЭ-ийн Хүндэт дэвтэр бичих
- МАЭ-ийн өргөмжлөл
- МАЭ-ийн УЗ-ийн шийдвэрээр МАЭ-ээс зохион байгуулагдаж буй арга хэмжээнд хөнгөлттэй нөхцөлөөр оролцуулах, гишүүдээ болон гишүүн байгууллагын ажилтануудыг бусад байгууллага, төрийн дээд шагналаар шагнуулахаар тодорхойлж нэр дэвшүүлж, дэмжлэг үзүүлнэ.

ГУРАВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ БОЛЗОЛ

3.1 “ШИЛДЭГ БҮТЭЭЛ”

Шилдэг бүтээлийн шагналд архитектур төлөвлөлтийн шилдэг шийдэлтэй, нийгмийн хэрэгцээг хангасан, байгаль орчинд ээлтэй техник технологи, шинэ материал, бүтээц ашигласан, баригдаж ашиглалтанд орсон, архитектур хот төлөвлөлт, ландшафт, хөшөө дурсгал, сэргээн засвар, интерьер, экстерьерийн бүтээлүүдийг нэр дэвшүүлнэ.

Нэр дэвшүүлсэн бүтээлийн мэдээлэл холбогдох зураг болон фотог хавсаргана.

Тухайн бүтээлийн талаар захиалагч, ашиглагч байгууллагын санал авна.

3.2 “ШИЛДЭГ АРХИТЕКТОР”

Зураг төслийн байгууллагад 10-аас доошгүй жил тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж, МАЭ-ийн гишүүнийхээ үүргийг амжилттай биелүүлсэн, архитектур хот байгуулалтын салбарт тухайн онд шилдэг бүтээл туурвисан /зураг төсөл нь магадлал хийлгэсэн, батлагдсан/, уран бүтээлээ МАЭ-ийн уран бүтээлийн фондод бүртгүүлсэн, ОУ-ын үзэсгэлэнд оролцсон батламж, шагналтай архитекторыг “ШИЛДЭГ АРХИТЕКТОР”-оор нэр дэвшүүлнэ.

3.3 “ШИЛДЭГ ЗАЛУУ АРХИТЕКТОР”

Зураг төслийн байгууллагад 3-аас дээш жил тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж, МАЭ-ийн гишүүнийхээ үүргийг амжилттай биелүүлж буй, архитекторын зэрэг, дэв хүртсэн, тухайн онд архитектур, хот байгуулалтын салбарт шилдэг бүтээл туурвисан, шинэ санаа дэвшүүлсэн, шилдэг бүтээлийн уралдаанд оролцсон, архитектурын шүүмж, нийтлэл бичсэн уран бүтээлээ МАЭ-ийн уран бүтээлийн фондод бүртгүүлсэн залуу архитекторыг /38 нас хүртэлх/ “ШИЛДЭГ ЗАЛУУ АРХИТЕКТОР”-оор нэр дэвшүүлнэ.

3.4 “ШИЛДЭГ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА”

3.4.1 Архитектурын сургалттай их дээд сургуулиуд

- Магадлан итгэмжлэгдсэн
- Архитектурын мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг ОУ-ын стандартаар боловсруулж хэрэгжүүлж үр дүнд хүрч байгаа байдал
- Дотоод гадаадад зохиогдож буй архитектурын чиглэлийн үйл ажиллагаа, уран бүтээлийн уралдаан, үзэсгэлэн бусад арга хэмжээнд багш оюутаны оролцсон байдал

- Санаачлан зохион байгуулсан онол практик, эрдэм шинжилгээний хурал, зарласан уран бүтээлийн уралдаан, үзэсгэлэн зохион байгуулсан байдал
- Төгсөгчдийн СҮ, дипломын хуулбар, ажил эрхлэлтийн судалгааг МАЭ-д ирүүлсэн байх
- МАЭ-ийн үйл ажиллагаанд оролцсон /гишүүн элсүүлэлт, гишүүний татвар төлөлт, “МА” сэтгүүл захиалсан байдал/, “Архитектур хөгжүүлэх сан”-д оролцсон, бусад хандив тусламж үзүүлсэн байдал

3.4.2 Бусад байгууллагууд

- Тухайн онд гүйцэтгэсэн архитектур төлөвлөлтийн зураг төслийн ололт амжилт
- Тухайн онд ИТА нь мэргэжил дээшлүүлсэн, сургалтанд хамрагдсан, мэргэшлийн зэрэг дэвээ ахиулсан байдал
- Тухайн онд болсон томоохон хурал зөвлөгөөнд оролцсон, илтгэл, уран бүтээлийн уралдаан, үзэсгэлэн конкурст хамт олноороо болон ИТА нь оролцсон байдал
- Тухайн онд санаачилсан, дэвшүүлсэн, нэвтрүүлсэн шинэ санаа, дэвшилтэт технологи, хандив тусламж үзүүлсэн байдал
- Шинээр нэвтрүүлсэн, хэрэгжүүлсэн программ хангамж тоног төхөөрөмж
- Зураг төслийн чанар, бусад ажлын талаар ирсэн гомдол, зөрчил, түүнийг арилгасан байдал.
- МАЭ-ийн үйл ажиллагаанд оролцсон /гишүүн элсүүлэлт, гишүүний татвар төлөлт, “МА” сэтгүүл захиалсан байдал/, “Архитектур хөгжүүлэх сан”-д оролцсон байдал, нийгмийн хариуцлагын байдал

ДӨРӨВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН БҮРДҮҮЛЭЛТ

- 4.1 Шагналд нэр дэвшүүлсэн албан тоотод Нэр дэвшигчийн анкет, ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт, уран бүтээлийн онцгой амжилт гаргасан бол гэрчлэх баримтын хуулбар, шагналд тодорхойлсон хурлын тэмдэглэл
- 4.2 МАЭ-ийн ямар шагналаар шагнуулахыг холбогдох байгууллагаас нь албан ёсоор тодорхойлж, 12 сарын 10-ны дотор МАЭ-ийн ажлын албанд ирүүлнэ.
- 4.3 Тодорхойлогч байгууллага нь тухайн шагналтай холбогдон гарах зарим зардалыг хариуцана. /цом, медаль, медалион, батламж хэвлүүлэх/
- 4.4 Материал дутуу ирүүлсэн бол хүлээн авахгүй

ТАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ ОЛГОХ

- 5.1 “ШИЛДЭГ БҮТЭЭЛ”-ийн зохиогчдыг МАЭ-ийн нэрэмжит шагналын Тэмдэг, батламж
- 5.2 “ШИЛДЭГ АРХИТЕКТОР”-оор шалгарсан архитекторт МАЭ-ийн Цом, батламж
- 5.3 “ШИЛДЭГ ЗАЛУУ АРХИТЕКТОР”-оор шалгарсан архитекторыг МАЭ-ийн медалион, батламж

5.4 “ШИЛДЭГ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА”-аар шалгарсан хамт олныг МАЭ-ийн Цом, батламж аар тус тус шагнаж урамшуулна.

ЗУРГАА. ШАЛГАРУУЛАЛТ

- 6.1 “Шилдэг”-үүдийг МАЭ-ээс томилогдсон комисс нь дээрх журмын дагуу ирсэн материалыг шалгаруулж, санал бэлдэж МАЭ-ийн ажлын албанд өгнө.
- 6.2 Шагналд нэр дэвшигчдийг шалгаруулах Комиссын саналыг МАЭ-ийн УЗ хурлаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ.
- 6.3 Шагналыг УЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн МАЭ-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар олгоно.

Монголын Архитекторуудын Эвлэл
Улаанбаатар 2017 он